

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

### НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2018 оны 4 сарын 17-ны өдрийн А/03 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Баяннуур сумын Бүрэн дунд сургуулийн 2016, 2017 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

### ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Л.Цэрэнбүтэд 2018 оны 4 сарын 17-ны өдрөөс 6 хоног шалгалтыг хийв.

### ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Бүрэн дунд сургуулийн 2016, 2017 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, шатахууны хэтрэлт хэмнэлт, зарцуулалт, дотуур байр болон үдийн цай хөтөлбөрийн хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

### ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Баяннуур сумын 1-р багт байрлах Сургууль нь 2016 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрэгжүүлэх, ур чадвар арга зүйгээ сайжруулан

суралцагчдад зөв хандлага төлөвшүүлж бүтээлчээр ажиллахад чиглүүлж тусгай төлөвлөгөө гарган хэрэгжилтэнд хяналт тавьж биелэлтийг тооцон ажилласан байна. 2016 оны хичээлийн жилд 292, 2017 оны хичээлийн жилд 274 суралцагчид суралцсан.

2016, 2017 онд орон тооны бүтэц, цалингийн сангийн тушаал гараагүй ч захирал, сургалтын менежер 1, багш 16 дотуур байрны багш, насан туршийн боловсролын багш, нийгмийн ажилтан, номын санч, нярав, үйлчлэгч 1, тогооч 3, дотуур байрны жижүүр 4, галч 4 нийт 33-35 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 2016 оны 01 сарын 01-ээс 2017 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл Ч.Сарантуяа, 2-р гарын үсгийг 2016 оны 01 сарын 01-нээс 2017 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Т.Ганчимэг нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 100041515101 тоот, нэмэлт санхүүжилтийн 100041515401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

#### ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус сургуулийн 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан нь түүвэрт хамрагдсан тул дүгнэлт гараагүй. 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан нь хязгаарлалтай дүгнэлт авсан байна.

2016 оны санхүүгийн үйл ажиллагаа, хууль журмын хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар

2017 оны 11 дүгээр сарын 3 –ны өдрийн БуТАГ-2017/06-НА/55-02 тоот актаар төсөвт төвлөрүүлээгүй 84200 төгрөгийг аймгийн аудитын газрын 100040051005 тоот дансанд төвлөрүүлсэн.

2017 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн БуТАГ-2017/06-НА-56/03 тоот актаар хүнсний материалыг илүү тооцсон 57875 төгрөгийг нярав Д.Пүрэвсүрэн, тогооч, дотуур байрны багш нараар хувь тэнцүүлэн төлүүлж аймгийн аудитын газрын 100040051005 тоот дансанд төвлөрүүлсэн.

2017 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн БуТАГ-2017/06-НА-57/04 тоот актаар анхан шатны баримтгүй 246490 төгрөгийг захирал Ч.Сарантуяа, нягтлан бодогч Т.Ганчимэг, нярав Д.Пүрэвсүрэн нараар хувь тэнцүүлэн төлүүлж аймгийн аудитын газрын 100040051005 тоот дансанд төвлөрүүлсэн.

2017 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн БуТАГ-2017/06-НА-58/05 тоот актаар анхан шатны баримтгүй 56500 төгрөгийг нярав Д.Пүрэвсүрэнгээр төлүүлж аймгийн аудитын газрын 100040051005 тоот дансанд төвлөрүүлсэн.

2017 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн БуТАГ-2017/06-НА-89/03 тоот албан шаардлагаар 5317538 төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлийг хангасан.

2018 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн БУА-2018/98/СТА-ТШЗ-01/07 тоот актаар анхан шатны баримтгүй зарцуулсан 1529800 төгрөгийг захирал Ч.Сарантуяа, нягтлан бодогч Т.Ганчимэг нараар төлүүлэх хугацаа болоогүй төлөөгүй байна.

2018 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн БУА-2018/98/СТА-ТШЗ-01/20 тоот албан шаардлагаар 2873850 төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчлийг арилгаж баримтыг бүрдүүлсэн.

## ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Сургуулийн 2016, 2017 оны касс харилцах, цалингийн баримт, захирлын тушаал, хүнс, бараа материалын баримт, 2016, 2017 оны санхүүгийн тайлан, дотуур байрны суралцагчдын ирцийн бүртгэл, 2016, 2017 оны хагас, бүтэн жилийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын баримт, хөдөлмөрийн дотоод журам зэрэг баримт материалуудад тулгуурлан захирал Ч.Сарантуяа, нягтлан бодогч Т.Ганчимэг, нярав Т.Эрхэмжаргал нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

### 6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2016 онд улсын төсвөөс 465164.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, 465164.6 төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансны 7964.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 7026.8 мянган төгрөг бүгд 480155.4 мянган төгрөгний эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2016 онд төсөвт зардлыг 465164.6 мянган төгрөгнийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 480155.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажиллагсадтай холбоотой зардалд 277494.7 мянган төгрөг, ндш-д 31059.1 мянган төгрөг, тогтмол зардалд 35551.8 мянган төгрөг, нормативт зардал 34820.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 3654.9 мянган төгрөг, БҮТЭЗ 1721.4 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 763.1 мянган төгрөг, томилолтын зардал 230.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардал 669.8 мянган төгрөг, ЖА тэтгэмж 7026.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 10156.2 мянган төгрөг, үдийн цай 15048.2 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 2493.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвортой ажилласан 9435.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж 16482.0 мянган төгрөг үлдэгдэл 33548.4 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

2017 онд улсын төсвөөс 487814.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 487815.0 мянган төгрөгийг авч, нийгмийн даатгалын сангаас 7035.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны 10221.2 мянган төгрөг бүгд 505072.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2017 онд төсөвт зардлыг 487814.9 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 504993.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажиллагсадтай холбоотой зардалд 284744.8 мянган төгрөг, ндш-д 31321.9 мянган төгрөг, тогтмол зардалд 25463.9 мянган төгрөг, нормативт зардалд 29841.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 5920.5 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 43316.1 мянган төгрөг, албан томилолтын зардалд 215.0 мянган төгрөг, БҮТЭЗ 4870.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 13904.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2379.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад таван жил тутамд олгох, тэтгэмжид 25226.4 мянган төгрөг, үдийн цай 12712.5 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 2490.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд

10500.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалт тоног төхөөрөмж 5050.0, ЖАТэтгэмж 7035.8 мянган төгрөг, үлдэгдэл 78.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

2017 онд Боловсролын тухай хуулийн 43.1 –ийн 4.1.7-д заасны дагуу тасралтгүй 5 жил ажилласан З.Ариунцэцэг, Ц.Цэндээхүү, Ё.Пүрэвдорж, Ч.Алтанзагас, Б.Эрдэнэтуяа, Э.Энхтуяа, А.Алтанцэцэг нарын 7 багшид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмж олгохоор төсөвт 25266.4 мянган төгрөг тусган олгосон ч тэтгэмж олгох тушаал шийдвэр гаргаагүй байна.

*Нэмэлт санхүүжилтийн* 100041515401 тоот дансаар БСШУЯ-наас хэрэгжүүлж буй боловсролын чанарын шинэчлэл төслийн сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрөөс 5886.8 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирснээс байгалийн ухааныг кабинет тохижуулахад 35 нэр төрлийн 184 ш 4398.5 мянган төгрөгний сургалтын хэрэглэгдэхүүн болон модон тавиур шүүгээ хийлгэхэд 508.3 мянган төгрөг, 42 инчийн өнгөт телевизор 980.0 мянгөн төгрөг зарцуулсан. Мөн төгсөгчдийн хандиваар 4275.2 мянган төгрөг, багш ажилчдын хандиваар 589.4 мянган төгрөг орсонг сургуулийн спорт заалны урсгал засварт зарцуулсан байна.

Цалин урамшууллын талаар:

2017 онд сургуулийн захирлын 2017 оны 03 сарын 23-ны өдрийн Б/12 тоот тушаалаар 32 ажилтанд 35-45%-иар 6858.2 мянган төгрөг, 2017 оны 06 сарын 15-ны өдрийн Б/19 тоот тушаалаар 32 ажилтанд 31-45%-иар 6262.5 мянган төгрөг, 2017 оны 09 сарын 27-ны өдрийн Б/28 тоот тушаалаар 32 ажилтанд 12-25%-иар 3551.6 мянган төгрөг, 2017 оны 12 сарын 14-ний өдрийн Б/38 тоот тушаалаар 35 ажилтанд 14-45%-иар 7376.1 мянган төгрөг нийт 24048.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон.

Сургуулийн захирал нь 1-р улирлын үр дүнгийн урамшуулалт цалинг Аймгийн Засаг даргын 2017 оны 04 сарын 25-ны А/238 дугаар захирамжаар 39%-иар 330.3 мянган төгрөг, 2-р улирлын урамшууллыг 2017 оны 07 сарын 20 -ны А/391 дүгээр захирамжаар 45%-иар 330.3 мянган төгрөг, 2017 оны 10 сарын 11-ны А/512 дүгээр захирамжаар 45%-иар 330.3 мянган төгрөг, 2017 оны 12 сарын 21-ны А/634 дугаар захирамжаар 45%-иар 330.3 мянган төгрөг нийт 1321.2 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон. Аймгийн Засаг даргын 2017 оны 04 сарын 11-ны А/200 дугаар захирамжаар ур чадварын нэмэгдэл 15%-иар 660.6 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2017 оны 10 сарын 11-ны А/514 дугаар захирамжаар ур чадварын нэмэгдэл 15% -иар 660.6 мянган төгрөг тус тус олгосон байна.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	нэмэгдсэн	хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	806220400.00	0	0	806220400.00
2	Авто тээврийн хэрэгсэл	20000000.00	0	0	20000000.00
3	Машин тоног төхөөрөмж	99536191.00	2047000.	24057232	77525959
4	Тавилга, эд хогшил	423990064.92	3820000	3763732.08	42455332.84
5	Номын фонд	4398058.40			4398058.40

6	Батлан хамгаалах тоног төхөөрөмж	999800.00			999800.00
7	Биет бус хөрөнгө	350000			350000
8	Бусад үндсэн хөрөнгө	15368590			15368590
	Дүн	989022104.92	6117000	27820964.08	967318140.24

2017 оны эхэнд 989022.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 980.0 мянган төгрөгийн телевизор, 3820.0 мянган төгрөгийн модон шүүгээ, тавиур, ширээ, 250.0 мянган төгрөгийн няравын программ нийт 5050.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө авсан. 1067.0 мянган төгрөгийн 1-р хоолны тогоо БСШУЯ –аас тоног төхөөрөмж, нийт 6117.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогдож сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 1 сарын 12-ны өдрийн 05 тоот тогтоолоор 64 нэр төрлийн 164 ш 24057.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3763.7 мянган төгрөгний хөрөнгө акталж жилийн эцэст 967318.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна. Тооллогын бүртгэлээр барилга 816658.2 мянган төгрөг 10437.8 мянган төгрөгөөр илүү, авто машин 5000.0 мянган төгрөг 15000.0 мянган төгрөг дутуу, тоног төхөөрөмж 69811.4 мянган төгрөг 7714.5 мянган төгрөгөөр дутуу, тавилга эд хогшил 31230.0 мянган төгрөг 11225.3 мянган төгрөгөөр дутуу, бусад үндсэн хөрөнгө 4580.6 мянган төгрөгөөр илүү байна.

**6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:**

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Хүнсний материал	8016380.05	27179885	31827540	3368725
2	Бичиг хэрэг	247 000	303820	213820	337000
3	Аж ахуйн материал	167224.95	26659440	10400811	16425853.95
4	Үдийн цайны материал	4197550	12712560	15956130	953980
5	Эм боох материал		244200	244200	
6	Барилгын засварын материал	280000	43996100	17816100	26460000
7	Түлш шатах тослох	3123595	23902300	23271945	3753950
8	Бусад хангамжийн материал	57400			57400
	НИЙТ ДҮН	16089150	134998305	99730546	51356909

2017 оны эхэнд 16089.1 мянган төгрөгийн бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 134998.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БСУГ-аас 5968.8 мянган төгрөгний байгалийн ухааны кабинетад 5 нэр төрлийн 33 ш багаж хэрэгсэл материалд орлого авч, 99730.5 мянган төгрөгийн материал зарлагдсан байна.

Бараа материалын тайлан санхүүгийн тайлангийн дүнгээс бичиг хэргийн зардал 247.0 мянган төгрөг, аж ахуйн материал 3775.2 мянган төгрөг, засварын

материал 680.0 мянган төгрөгөөр дутуу, түлш шатахуун 31.0 мянган төгрөг, дотуур байрны хүнс 99.2 мянган төгрөгөөр илүү байна.

6.4. Өглөг, авлагын талаар: 2017 оны эцэст байгууллагад төлөх өглөгт 1688.9 мянган төгрөгийн өглөгтэй байсныг барагдуулсан ч, 2017 оны эцэст 1446.1 мянган төгрөгийн хаот-т өглөгтэй, оны эхний авлага 218.2 мянган төгрөгний авлагатай байсанаас авлага барагдаагүй байна. /эзэн холбогдогч нь нас барсан/

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2016 онд нийт 117 мэдээлэл оруулахаас 102 мэдээллийг хугацаанд нь 15 мэдээллийг хугацаа хоцроосон, 2017 онд нийт 149 мэдээлэл оруулахаас 131 мэдээллийг хугацаанд нь 18 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

#### ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 7 багшид олгосон тэтгэмжид тушаал гаргаагүй.

2. 2017 оны 1-р сарын 08-ны Б/06 ажлын хариуцлага алдсан багш З.Ариунцэцэгт, мөн оны 6 сарын 13-ны өдрийн Б/16 тоот тушаалаар дотуур байрны багш Д.Гантөмөр нарт сануулах арга хэмжээ авсан байна. Сургуулийн захирлын 2017 оны 12 дугаар сарын 14-ны Б/40 тоот тушаалаар Улсын их хурлын 2017 оны 11-р сарын 09 өдрийн 67 дугаар тогтоол үндэслэн ажилчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо Монгол улсын засгийн газрын 2017 оны 12 сарын 6-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийг зөрчин сахилгын шийтгэл хүлээсэн 2 багшид 486.0 мянган төгрөг олгосон.

3. Аймгийн Засаг даргын 2016 оны 05 сарын 27-ны өдрийн А/257 тоот захирамжийн дагуу ур чадварын нэмэгдэл олгохдоо 7 сараар олгож нэг сарын ур чадварын мөнгө 146811 төгрөг, Аймгийн Засаг даргын 2017 оны 04 сарын 25-ны А/238 дугаар захирамжаар 39 % -иар дүгнэгдэж ирсэнийг 45 %- иар 330.3 мянган төгрөг авч 44046 төгрөг нийт 190857 төгрөг илүү олгосон.

4. Цалингийн урьдчилгаа 4 багш ажилчидаас 973.2 мянган төгрөг дутуу суутгасан.

5. Үдийн цай, дотуур байрны хүнс, шатахуун, түлээ, бичиг хэргийн тайлангаас бусад сэлбэг хэрэгсэл, нормын хувцас зөөлөн эдлэл, урсгал засварын материалын тайлангуудыг тусад нь гаргадаггүй.

6. Нярав Д.Пүрэвсүрэнгийн харилцах дансаар материалын үнэ 4016.9 мянган төгрөгийг гаргаж зарцуулсан ч бэлэн мөнгөний тайлан гаргаагүй.

7. Шуудан холбооны зардлаас 2017 онд захирал, менежер, нийгмийн ажилтан, нарын гар утасны зардалд 40.0 мянган төгрөг зарцуулсан нь 2016 оны УИХ-ын 47 дугаар тогтоолын 2-д /Албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй/ гэсэн заалтыг зөрчсөн.

8. Албан томилолтын зардал 5 хүнд 215.0 мянган төгрөг олгохдоо томилолтын хуудасны тооцоо хийсэн дарга нягтлан бодогч зөвшөөрсөн ажилтанаар гарын үсэг зуруулаагүй.

9. Хөрөнгө зарцуулах захирлын тушаал 2017 онд 12 гарч 3111.6 мянган төгрөг гаргасан боловч мөнгөний зарцуулалт хийдэггүй.

10. Хүнснээс бусад бараа материалд агуулахын бүртгэл хөтөлдөггүй, орлого зарлагын баримт болон шаардах хуудсыг оны эхнээс дугаарлаагүй, шаардах хуудсанд нягтлан бодогч гарын үсэг зурдаггүй.

11. Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл болон бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайлангийн дүнтэй зөрүүтэй.

12. Шатахууныг авсан хэмжээгээр зарлагаддаг, хэтрэлт хэмнэлтийн тооцоо боддоггүй.

#### ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 3 актаар 1650.0 мянган төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлхээр, үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдэлийг тохируулах албан шаардлага бичлээ. Үндсэн хөрөнгө болон бараа материалын тайлангийн үлдэгдлийг санхүүгийн тайлантай дүнг тааруулахаар албан шаардлага бичлээ. Шалгалтын хугацаанд 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

#### АРАВ. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь /шинэчилсэн/, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтуудын хэрэгжилт хангалтгүй, мөн шалгалтаар илэрч байгаа нийтлэг зөрчлүүд нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт сул байна гэж дүгнэлээ.

#### АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Бэлэн мөнгө татаж зарцуулахыг таслан зогсоож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7-дахь заалтууд, Засгийн газрын 393 дугаар тогтоол, БСШУЯ-ны сайдын 293 дугаар тушаал, Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлэх

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧ                      Л.ЦЭРЭНБҮТЭД

Төлбөр хариуцуулан төлүүлэх  
тухай

Булган аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, аймгийн засаг даргын баталсан А/03 тоот удирдамжийн дагуу Дашинчилэн сумын 4-р багт байрлах 12 жилийн бүрэн дунд сургуулийн 2016, 2017 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг касс, харилцахын баримт, няравын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журнал, эрхлэгчийн тушаал, цалин олгох хүснэгт, нийгмийн даатгалын болон татварын, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын газрын дүгнэлт зэрэг баримт материалуудад тулгуурлан захирал Ю.Цогмандах, нягтлан бодогч Р.Билгүүмаа нарыг байлцуулан Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Л.Цэрэнбүтэд 2018 оны 04 сарын 23-аас 6 өдөр төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Шалгалтаар аймгийн Засаг даргын 2017 оны 9-р сарын 28-ны А/01 тоот захирамжаар сануулах арга хэмжээ авагдсан боловч 2017 оны 12 сарын 12-ны өдрийн А/365 тоот захирамжаар Улсын их хурлын 2017 оны 11-р сарын 09 өдрийн 67 дугаар тогтоол үндэслэн ажилчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо Монгол улсын засгийн газрын 2017 оны 12 сарын 6-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийг зөрчин 243.0 мянган төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 10.12.2-д /Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ./ заасан заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Үр дүнгийн урамшуулалд олгосон 243.0 мянган төгрөгийг захирал Ю.Цогмандахаар төлүүлж төсвийн орлого болгосугай.

2. Төлбөрийн 243.0 мянган төгрөгийг аймгийн төрийн сан дахь төсвийн орлогын 100040000952 тоот дансанд 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэхийг захирал Ю.Цогмандах, нягтлан бодогч Р.Билгүүмаа нарт актаар хариуцуулсугай.

3. Төлбөрийг үндэслэлгүй гэж үзвэл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д /Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана./ заалтыг үндэслэн гомдлоо 30 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

ТОГТООСОН:

ЗӨВШӨӨРСӨН:



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  
Д.САРАНГЭРЭЛ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ  
Л.ЦЭРЭНБҮТЭД

ДАШИНЧИЛЭН СУМЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ю.ЦОГМАНДАХ  
НЯГТЛАН БОДОГЧ  
Р.БИЛГҮҮМАА